



ТӨВ АЙМГИЙН АХМАДЫН ЧӨЛӨӨТ ХОЛБООНЫ 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мэйл: jargalsaihan_tuv@yahoo.com

Утас: 70272582

Факс: 01-272-22582

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мэйл: amaraa_tuv@yahoo.com

Утас: 70273465

Ахлах аудитор

Т.Майцэцэг

Утас: 70273463 99018619

И-Мэйл: maits2009@yahoo.com

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Ахмадын чөлөөт холбооны төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд / ТӨВ-2015/114/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Ахмадын чөлөөт холбооны төсвийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Ахмадын чөлөөт холбоо нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Ахмадын чөлөөт холбооны 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 26-наас 2015 оны 03 дүгээр сарын 28-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор Т.Майцэцэг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Ахмадын чөлөөт холбоо нь 2014 оны төсвийн санхүүгийн тайланг 2015 оны 01 дугаар сарын 26-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 26-наас 2015 оны 03 дүгээр сарын 27-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 03 дугаар сарын 31-нд Төв аймгийн Ахмадын чөлөөт холбооны удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, НББ-ийн тухай, хөдөлмөрийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Төрийн байгуулагатай гэрээний үндсэн дээр ахмад настны эрхийг хамгаалах үүргийг гүйцэтгэдэг хоёрдмол шинж чанартай хоёрдмол удирдлагатай Монголын ахмадын чөлөөт

холбоо НҮТББ, Монголын ахмадын холбоо ТББ гэсэн 2 байгууллага 2013 оны 05-р сарын 22-ний өдөр ахмад настны нийтлэг эрх ашгийг төлөөлөхөөр гэрээ байгуулсан.

МУ-ын Ерөнхий сайд 2013 оны 8-р сарын 07-ний өдрийн цахим хурлаар орон нутгийн удирдлагуудад Монголын ахмадын Чөлөөт холбоотой хамтран ажиллах мэдэгдэл өгснөөр тус байгууллага нь орон нутгийн төсвөөс санхүүжигдэж байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Төв аймгийн Ахмадын чөлөөт холбооны тэргүүн Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаас орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталж Төв аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Ахмадын чөлөөт холбооны төсвийн 2014 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Ахмадын чөлөөт холбооны удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан 6 горим сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж 2014.05.09-ний өдрийн Төв аймаг дах ахмадын чөлөөт холбооны даргын тушаалаар баталж мөрдөж байна.

Төв аймгийн Ахмадын чөлөөт холбооны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг гараар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналттай танилцахад Төв аймгийн ахмадын чөлөөт холбооны даргын 2014.03.01-ний өдрийн 22 тоот тушаалаар Дотоод хяналтын албыг зохион байгуулагч Т.Болдоор ахлуулан 3 гишүүнтэйгээр байгуулсан байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Ахмадын чөлөөт холбооны ХААН банкны харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэн байна.

Төв аймгийн Ахмадын чөлөөт холбоо нь 2014 онд аймгийн төсвөөс урсгал зардалд 61715.3 мянган төгрөгийн санхүүжилтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу бүрэн авсан.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 6 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төв аймгийн Ахмадын чөлөөт холбооны төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний дүнтэй ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг бус хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Санхүүгийн тайлангийн Нийт хөрөнгийн эхний болон эцсийн үлдэгдэл өр төлбөр, цэвэр хөрөнгийн эхний болон эцсийн үлдэгдэлтэй 3683.0 мянган төгрөгөөр зөрүүтэй байсан. Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Аудитын явцад алдааг залруулсан

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулах материаллаг бус алдаа тогтоогдоогүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж хөрөнгийн тооллогыг түүвэрлэн тооллох асуудлыг завсрын аудитаар нөхөн шалгахаар тогтоов.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төв аймгийн Ахмадын чөлөөт холбооны төсвийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 3683.0 мянган төгрөгийн алдаа илэрснийг аудитын явцад залруулсан

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх аудитаар 3 зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн хариуг 2014.05.29-ний өдөр 101 тоот бичгээр хариуг ирүүлсэн. Зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:
Зөрчилгүй санал дүгнэлт

Төв аймгийн Ахмадын чөлөөт холбоо нь төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудас, байгууллагын санал . хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ЖАРГАЛСАЙХАН

АУДИТЫН МЕНЕЖЕР

О.АМАРЖАРГАЛ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР

Т.МАЙЦЭЦЭГ

